

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2025 оны 12 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Дүүргийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

Нэг.Танилцуулга:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд зохион байгуулан ажиллаа.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын “Үнэлгээ хийх” журмын 3.2-т заасны дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/223 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Үнэлгээний багийг байгуулан, ажлын даалгавар боловсруулан ажилласан.

Багийн гишүүдэд:

Багийн ахлагч: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Багийн гишүүд: Дүүргийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Үүрэг даалгаварын биелэлт, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Ахлах мэргэжилтэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хороодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтэн

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Багийн нарийн бичгийн дарга Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Бодлогын баримт бичгийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтэн нар ажиллав.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилго, хамрах хүрээ:

Хяналт-шинжилгээний зорилго нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт нь үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, явцын үнэлгээ хийж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

Гурав.Үнэлгээний арга, аргачлал:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын 3.7-д заасан аргачлал болон хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний 14 асуумжтай маягт боловсруулав.

$$\text{Төлөвлөгөөний хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \times 100\%$$

№	Зорилтын нэр	Зорилтын тоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Гүйцэтгэлийн хувь			ХШҮ дүн
				Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. Бодлогын баримт бичиг тусгагдсан зорилт арга хэмжээ							
“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:							
1	Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	1	1	1	-	-	100
2	Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.	1	1	1	-	-	100
ДҮН		2	2	2			100
Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хамааралтай заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:							
3	Эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн халдварт бус өвчин, тэр дундаа зонхилон тохиолдох өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоог эрчимжүүлж, эмчилгээнд бүрэн хамруулах, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.	1	1	1	-	-	100
ДҮН		1	1	1			100
Дүүргийн Засаг даргын 2024-2025 оны үйл ажиллагааны хөтөлөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд:							
Зорилго 1.Бүсчилсэн хөгжлийн бодлого							
4	Хот, суурин газрын иргэдийн ая тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	1	4	2	1	1	83,2 5
5	Дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, авто зам, замын байгууламж, гэрэлтүүлэг, инженерийн шугам сүлжээний хүчин чадал, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэлийг бууруулна.	1	6	4	2		92.8
Зорилго 2.Хүний хөгжлийн бодлого							
6	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулан, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	3	2	-	1	83,3

7	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг эрчимжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, өвчлөл, эндэгдлийг бууруулна.	1	2	2	-	-	90
8	Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, тогтвортой ажиллах нөхцөл, боломж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.	1	3	2	-	1	83,3
9	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, яаралтай тусламж үзүүлэх чадавхийг нэмэгдүүлнэ.	1	2	2	-		100
10	Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, эмчлэх үйл ажиллагааг "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1	3	2	1		93,5
11	"Хүн амын чанартай, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1	3	3	-		97,3
12	Ахмадын хөгжлийн төвүүдийг байгуулан, "Ахмад настны хөгжлийг дэмжих" төсөл хэрэгжүүлнэ.	1	1	-	1		80,1
13	Багш, суралцагчдын хөгжлийг дэмжин, чадавхижуулж, хүүхэд бүрд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй хүргэн, сургалтын байгууллагын орчныг сайжруулна.	1	11	10	1		96
14	Олон нийтэд чиглэсэн нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцлийг нэмэгдүүлэн, биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	1	5	5	-		100
15	Иргэдийн соёлын боловсролыг нэмэгдүүлэн, соёл, урлагийн үйл ажиллагааг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, түүх, соёлын дурсгал, өвийг хадгалж, хамгаалах, илрүүлэх, өвлүүлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.	1	3	3	-		95
16	Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулж, хөгжил хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг бий болгоно.	1	7	7	-		98
17	Иргэдэд жендерийн боловсрол олгох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг хэрэгжүүлнэ.	1	3	-	3		70
Зорилго 3.Эдийн засгийн бодлого							
18	Орон нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөж, ил тод мэдээлнэ.	1	6	6	-		100
Зорилго 4.Ногоон хөгжлийн бодлого							
19	Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.	1	3	2	-	1	51,4
20	Хөрсний бохирдлыг бууруулах ажлыг иргэдийн оролцоотой хамтран санал санаачилга гарган ажиллана.	1	1	1	-		86
21	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, орчныг бохирдлыг бууруулах эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	1	2	-	2		70

22	Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орчны доройтлыг бууруулж, иргэдийн аюулгүй байдлыг хангана.	1	2	2	-		100
Зорилго 5.Засаглалын бодлого							
23	Засаглал, цахим шилжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	1	4	3	-	1	77,5
24	Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	1	4	2	-	2	70
25	Батлан хамгаалах хууль, тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавин, иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.	1	3	3	-		100
26	Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн албан хаах үүргийн биелэлтийг хангуулах, дайчилгааны болон томилгоот нэгжийн сургалт, дадлагын ажлыг зохион байгуулж, нөөцийн чадавхыг нэмэгдүүлнэ.	1	4	4	-		96,95
27	Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.	1	1		-		100
28	Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн байгууллага, албан хаагчдын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	2	2	-		100
ДҮН		25	88	70	7	4	89,2
1-Р ХЭСГИЙН ДҮН		28	91	73	11	7	96,4

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:							
1	Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлын хүрээнд.	1	7	5	1	1	82.8
2	Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, мэдээллийн техник технологийг сайжруулах, мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлнэ.	1	13	10	2	1	93.1
2-Р ХЭСГИЙН ДҮН		2	20	15	3	2	88
ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1	Дүүргийн төрийн албан хаагчдыг авилгаас ангид мэргэшсэн, ур чадвартай, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж, шатлан дэвшүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэж, төрийн албаны стандарт баримтлан мэдээллийн технологийг нэвтрүүлнэ.	1	15	11	0	4	82,02
3	Гэмт хэрэг зөрчлийг бууруулахад иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, архидаан согтуурах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, буруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	1	5	2	0	3	53,6

4	Орон нутгийн санхүүгийн хараат байдлыг багасган бие даан хөгжих нөхцөлийг дээшлүүлж, татварын орлогыг нэмэгдүүлнэ.	1	14	10	3	1	88,9
5	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, илэрсэн дутагдлыг арилгуулах, үр дүнг тооцно.	1	33	20	6		81,9
6	Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавин, иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.	1	5	4	0		84
3-Р ХЭСГИЙН ДҮН		6	72	47	9		84
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
1	Гэр бүл, хүүхэд залуучуудын эрхийг хамгаалах, тэмдний оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлд суурилсан хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжинэ.	1	2	2	-	-	100
2	Шинээр байгуулагдах хотуудын онцлогт нийцсэн худалдаа үйлчилгээний борлуулалтын цэгийг төрөлжүүлэн бий болгож, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, зорилтот бүлэгт чиглэсэн ажлын байрыг нэмэгдүүлнэ	1	4	2	1	1	81,2
3	Төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус олон улсын байгууллагыг түшиглэн хэрэгжүүлж, халамжаас хөдөлмөрт бодлогыг үргэлжлүүлнэ.	1	1	1	-	-	100
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг түгээх, шинээр ашиглалтад орж барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хотын стандартад нийцүүлнэ.	1	2	2	-	-	100
5	Иргэдийн нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	1	1	-	-	1	50
6	Инновац, гарааны бизнес, үйлдвэрлэлийг дэмжин, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, иргэдийг баталгаат хүнсээр хангана.	1	11	8	-	2	82,7
7	Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрмжөөр ханган, барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.	1	8	6	2	-	90
8	Багш, суралцагчийн хөгжлийг дэмжин чадавхжуулж, хүүхэд бүрд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй хүргэн, сургалтын байгууллагын орчныг сайжруулна.	1	3	2	1	-	90
9	Өвлийн спортын ордон, усан спорт сургалтын төв, хөл бөмбөгийн талбай бүхий спорт цогцолборуудыг ашиглалтад оруулна.	1	3	3	-	-	98,3

10	Шинээр байгуулагдах хотуудад соёлын орон зай бүхий соёл, урлагийн олон төрөлт үйлчилгээтэй төвүүдийг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	1	1	-	-	-	90
11	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, соёл амралт, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ.	1	1	-	-	1	-	30
12	Иргэд олон нийтийн дунд хотын соёлыг дээшлүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.	1	11	8	-	-	3	100
13	"Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагааг дэмжиж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үзүүлнэ	1	1	1	-	-	-	100
14	Залуучуудын хөгжлийн үйлчилгээний төвийг байгуулж, залуу гэр бүлийг дэмжиж ажиллана.	1	1	-	-	-	1	ХБ
15	Орон нутгийн төсвийн зарцуулалт, төрийн үйлчилгээний хэвийн байдлыг ханган ажиллах	1	3	3	-	-	-	100
4-Р ХЭСГИЙН ДҮН		15	53	39				86,5

Жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан гүйцэтгэлээр:

№	Бодлогын баримт бичгийн нэр	Зорилтын тоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Гүйцэтгэлийн хувь					Нийт хувь
				Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй	Хугацаа болоогүй	
1	Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн тайлан.	51	236	197	19	11	9	-	91,8

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.4-т заасан аргачлалын дагуу дүгнэж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн дүн:

№	Зорилтын нэр	Зорилтын тоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Гүйцэтгэлийн хувь			ХШҮ дүн
				Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	
1	Нэгдүгээр хэсэг буюу Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	28	91	73	11	7	96,4
2	Хоёрдугаар хэсэг буюу Засаг даргын тамгын газрын дүрмээр хүлээсэн үнсэн чиг үүргийн хүрээнд	2	20	15	3	2	88
3	Гуравдугаар хэсэг буюу Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	6	72	47	9	-	84
4	Дөрөвдүгээр хэсэг буюу Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг зорилт, арга хэмжээ	15	53	39	-	-	86,5
Нийт		51	236	174	23	9	88,7

Дөрөв.Үнэлгээний олдвор:

№		Нотломж				
		Захирамж, тушаал	Илтгэх хуудас	Тайлан, судалгаа	Төсвийн зарцуулалтын тайлан	Бусад
1	Нэгдүгээр хэсэг буюу Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	3	48	1	-	3
2	Хоёрдугаар хэсэг буюу Засаг даргын тамгын газрын дүрмээр хүлээсэн үнсэн чиг үүргийн хүрээнд	-	-	-	-	-
3	Гуравдугаар хэсэг буюу Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	-	-	-	-	-
4	Дөрөвдүгээр хэсэг буюу Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг зорилт, арга хэмжээ	-	-	-	-	-
НИЙТ		3	48	1	-	3

Тав.Үнэлгээний дүгнэлт:

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулахад нийт 236 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр нь :

Арга хэмжээг оновчтой тодорхойлсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, зорилтот түвшиндээ хүрээгүй ч бодит үр гарч эхэлсэн 174 зорилтын хэрэгжилтийг 85 буюу түүнээс дээш хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлсэн.

Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, цаашид зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай 23 зорилтын хэрэгжилтийг 70-85 хүртэл хувь буюу “Хангалттай” гэж үнэлсэн.

Төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй 9 зорилтын хэрэгжилтийг 70 хүртэл буюу “Хангалтгүй” гэж үнэлсэн.

Зургаа.Зөвлөмж

1. Арга хэмжээг төлөвлөхдөө хүрэх түвшинг өмнөх оны суурь түвшинтэй харьцуулж биелэх боломжтой, бодитой судалгаанд үндэслэх
2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа товч тодорхой, тоо баримттай, үр дүнг тооцсон байх
3. Нотлох баримтыг pdf файлаар хавсаргах, зөв бичих дүрэм болон найруулга зүйг анхаарч 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах

4. Нэгжийн дарга нар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарч, төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хийж гүйцэтгэх
5. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг уншиж судлах

Долоо.Хавсралт

Нотлох баримтыг хавсаргав.

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ДАРГА

 (С.ТУУЛМАА)

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮД

 (Т.СҮХБААТАР)

 (Б.МӨНХЗУЛ)

 (О.ЯНЖИНЛХАМ)

 (Ш.ОЮУН-ЭРДЭНЭ)

 (Л.ОЮУНДАРЬ)

 (Ө.НОРОВДЭМИД)

“Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын
3 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ (2025 он)

2025 оны 12 сарын 03-ны өдөр				Улаанбаатар хот		
Д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот	Хүрсэн	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт)	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	5	12	1.Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх 40 цагийн сургалтад-44, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-1, давтан сургалтад-2, Худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох 2 удаагийн сургалтад-27, Үндэсний бичгийн анхан, дунд шатны 3 удаагийн сургалтад 130, “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ” 8 цагийн сургалтад 43, Авлигын эсрэг сургагч багш бэлтгэх сургалтад-1, Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад-1, Хороодын Зохион байгуулагч нарын мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх,
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	2	3	
			Мэргэшүүлэх сургалт	2	3	
			Туршлага солилцох арга хэмжээ	1	1	
		1.2	Бусад	-	5	
			Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	198	305	
			Эмэгтэй албан хаагч	-	252	
		Үүнээс	Эрэгтэй албан хаагч	-	53	
			Удирдах албан тушаалтан	-	23	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	282	
		1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	-	80,5%	

						харилцан суралцах арга зүйн сургалтад 55 албан хаагч тус тус хамрагдсан.
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт)	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	1	1	АНУ-ын Вашингтон хотын Потомак Их сургуультай хамтран ажиллах "Санамж бичиг" байгуулсны дагуу төрийн захиргаа, хүний нөөцийн менежмент, төсөв санхүүгийн чиглэлээр "Гүйцэтгэх удирдлагын гэрчилгээний хөтөлбөр"-т сургалтад дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд болон ЗДТГ-ын албан хаагчид 2025.09.08-наас 19-ний өдрүүдэд хамрагдсан.
		Үүнээс	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	10	17	
			Эмэгтэй албан хаагч	-	8	
			Эрэгтэй албан хаагч	-	9	
			Удирдах албан тушаалтан	-	10	
2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал:		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	7	
				10-аас дээш	17	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)		157,5	
4	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	4.1	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)		13,7%	
		4.2	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо	5	Хорооноос дүүргийн ЗДТГ-т шатлан дэвшүүлж томилсон.	
			Эмэгтэй албан хаагч	5		
			Эрэгтэй албан хаагч	-		
		Үүнээс	Удирдах албан тушаалтан	-		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	5		

		4.3	Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	44	-
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	37	-
			Эрэгтэй албан хаагч	8	-
			Удирдах албан тушаалтан	3	-
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	41	-
		Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ			
5.	Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг (төгрөг)			4,149,540,716	Тайлант оны гүйцэтгэлээр
	5.1.Улирлын урамшуулал олгосон байдал		Нийт албан хаагчийн тоо	379	
			Урамшуулал олгосон албан хаагчийн тоо	294	
		Үүнээс	Удирдах	62	
			гүйцэтгэх	232	
			Нийт олгосон урамшууллын хэмжээ	397,532,398	
	5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт: 5.2.1.албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2)	Үүнээс	I улирал	-	-
			II улирал		Засаг даргын Тамгын газар, хороодын төрийн албан хаагчдын 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин, хөдөлмөрийн гэрээний үр дүнг тооцож нийт 294 албан хаагчид урамшуулал олгосон байна.
			III улирал	-	-
			IV улирал	-	-
		Цалингийн нийт санд эзлэх хувь		2.6%	
		албан хаагчийн тоо		11	
		нөхөх төлбөрийн хэмжээ		68,395,250	
		албан хаагчийн тоо		8	-
		нөхөх төлбөрийн хэмжээ		46,811,250	
		албан хаагчийн тоо		-	-

5.2.2.албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.2)	нөхөх төлбөрийн хэмжээ		
5.2.3.төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 5.1, 5.2)	албан хаагчийн тоо	1	-
5.2.4.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 7.1)	нөхөх төлбөрийн хэмжээ	1,584,000	--
5.2.5.гадаад улс болон орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 4.1)	албан хаагчийн тоо	2	-
5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 6.1)	нөхөх төлбөрийн хэмжээ	20,000,000	-
5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	албан хаагчийн тоо	-	-
5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4)	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3)	албан хаагчийн тоо	354	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	2,365,300,700	-
	албан хаагчийн тоо	354	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	2,365,300,700	-
	албан хаагчийн тоо	-	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-

5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.5)	албан хаагчийн тоо	-	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.6)	албан хаагчийн тоо	4	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	92,631,632	-
5.4.Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:	албан хаагчийн тоо	4	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	92,631,632	-
5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	албан хаагчийн тоо	-	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	албан хаагчийн тоо	127	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	1,225,680,736	-
5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон	албан хаагчийн тоо	-	-
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.5.2.орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг	албан хаагчийн тоо	31	Орон байрны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.
	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	443,560,000	
5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	778,090,736	Дүүргийн ЗДТГ-ын 1, 2, 3 дугаар байр болон 15 хорооны байранд албан

	5.5.4. албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш	албан хаагчийн тоо зарцуулсан хэмжээ	хөрөнгийн	96	хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулан засвар үйлчилгээ хийсэн.
				4,030,000	Эрт илрүүлэгт-53 Урьдчилан сэргийлэх үзлэг-43 Үүнээс 27 нь эрт илрүүлэгт өмнө хамрагдсан тул 4,030,000 төлбөр байгууллагаас төлөгдсөн.

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж БАТ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА *Aina* А.БЯМБА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН *Adlany* Ц.МӨНХЦЭЦЭГ